

ТАНИЛЦУУЛГА

2019 онд Дэлгэрцогт сумын төрийн захиргааны
байгууллага, албан тушаалтанд хандаж
иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн
тухай

2019-12-24

Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Багийн Засаг дарга болон мэргэжилтнүүдэд хандан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэхдээ холбогдох албан тушаалтнууд "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" Монгол улсын хууль, Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 67-р тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон амаар, бичгээр, 98133483 утсаар, цахимаар болон боломжит бүхий л хэлбэрээр хүлээн авч, шийдвэрлэлтийн явцыг байгууллагын удирдах ажилтнууд, мэргэжилтнүүдийн цуглаанд танилцуулан ажиллаж байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн СӨГ-ыг СӨГ бүртгэх дэвтэрт бүртгэн, холбогдох албан тушаалтанд өгч шийдвэрлүүлж, хариуг эзэнд нь утсаар болон албан тоотоор өгч байна.

2019 онд иргэдээс нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж амаар бичгээр нийт 159 өргөдөл, санал, хүсэлт ирүүлснийг 100% хугацаанд нь шийдвэрлэлээ..

Эдгээр санал, өргөдөл, хүсэлт нь газар эзэмших, өмчлөх, ашиглах, овог нэр солих, халамжид хамрагдах зэрэг асуудлууд байлаа.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:
ЗДТГ-ЫН ДАРГА  С.НАРАНТУНГАЛАГ

